



ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК-Н ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

№002/001/20250215-002

2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7.31.16 дахь заалтад тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Газар шим үйлдвэр ХК-ийн 2024 оны жилийн эцсийн цэвэр ашигаас нэгж хувьцаанд 2.6 (хоёр төгрөг, жаран мөнгө) төгрөг, нийт 3,115,094,338 (гурван тэрбум, нэг зуун арван таван сая, ерэн дөрвөн мянга, гурван зуун гучин найм) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, холбогдох хууль журамд нийцүүлэн 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар олгосугай.
4. Ногдол ашиг хуваарилж, олгох тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, ногдол ашгийг холбогдох хууль тогтоомж, энэхүү тогтоолд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд олгохыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ганбат)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ш.АЛТАНБАГАНА